



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 26/01

Улаанбаатар хот

“Илч-Орд” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.4, 52.1.12, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Илч-Орд” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц, орон тоог нэгдүгээр, цалингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.“Илч-Орд” ОНӨААТҮГ-ын захиралтай гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3.Батлагдсан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан шинэчлэн тогтоосон цалингийн хэмжээг 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Илч-Орд” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал (Д.Гантулга)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, Хот байгуулалт, дэд бүтцийн хороонд тус тус даалгасугай.

5.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Илч-Орд” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц орон тоо, цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” А/01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ф.МӨНХГЭРЭЛ

D:\2026 on\Togtool A.docx

1226010001